



“Ардын эрх” сонины 2000 дахь дугаарын зочноор УИХ-ын дарга З.Энхболд уригдлаа. -Ирэх намрын чуулганаар хэлэлцэх гол асуудал юу билээ, ямар бэлтгэл хийж байна вэ? Чуулган завсарласан хугацаанд оороо ямар ажил амжуулж байна?-Булган, Орхон аймгийн хадлан тэжээл, ургац хураалт, буцах замдаа Хотолйн цемент, Дарханы хар томорлогийн вйлдвэрээр орж, хоёр хоног томилолтоор яваад ирсэн. Оор томилолт байхгүй. Нэг ажлын хэсгийг УИХ-аас гаргасан, УИХ-ын гишүүн Ж.Батзандан ахлаад ажиллаж байгаа. Барилгын вйлдвэрлэл гурван ч хвний аминд хүрлээ шүү дээ. Хууль нь болохгүй байна уу, эсвэл хуулиа биелүүлэхгүй байна уу, цаашид яавал хвний амь эрсдэхгүй байх вэ гэдгийг судлуулахаар аравдугаар сарын 5 хүртэл үүрэг огоод 6-7 гишүүн ажиллаж байгаа. Томилолтоор оор тийшээ явахгүй гэсэн гишүүд ажлын хэсэгт орсон. Ээлжит бус болон ээлжит чуулганы хооронд ердөө аравхан хоногийн зай бий. Энэ богино хугацаанд их олон гишүүн томилолт авч тойрог руугаа явж байна.

-Ээлжит бус чуулганы хугацаанд ирц хүрэхгүй байдал үүсч байсан шүү дээ. Томилолтыг яаж хязгаарласан юм, нэг удаад хэдэн гишүүн нэгэн зэрэг томилолттой байж болох гэхчилэнгээр. Гадаад, дотоод ялгаагүй?

-Ер нь бол чуулгантай хугацаанд гадаад томилолт байхгүй, дотоод томилолт ч байхгүй. Чуулган хуралдаагүй үед бол тойрогтоо ажиллах нь чолоотэй байгаа.

-Чуулган хуралдах одор нь ажлын тав хоногийн хоёр нь л байгаа шүү дээ?

-Чуулгангүй үе гэдэг нь цагаан сараас дорөвдүгээр сарын 5, наадмаас аравдугаар сарын 1 хүртэл.

-Гишүүд энэ хязгаарыг барьж чадаж байгаа юу?

-Томилолт огохгүй бол явахгүй л дээ. Ажил таслаад ооринхоо монгоор явж болно.

-Намрын чуулганаар ямар асуудал хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа вэ?

-Хэлэлцэх асуудлыг баталсан, тэр хуваариар явна. Намрын чуулганаар толовсон толовлоогүй хэлэлцдэг улсын тосов, үндсэн чиглэл, тосвийн гүйцэтгэл зэрэг жижүүрийн асуудлууд дээр нэмээд хэд хэдэн асуудал байгаа. Улсын тосвийн хэлэлцүүлэг гэхэд бүхэл

бүтэн хоёр сарыг авдаг шүү дээ. Арван сар, арван нэгдүгээр сарыг бүтэн.

-Омно нь олон жил ужиг болон яригдаж байсан асуудлуудаас аль нь явж байгаа вэ? Үндсэн хуулийн оорчлолт, засаг захиргааны нэгжийн хуваарьт оруулах оорчлолт ч юм уу? Урьд нь танай нам цоонх байхдаа оруулж ирж байсан, бас нь нийгмийн зүгээс нэлээд дэмжлэг аваад байсан асуудлуудын цомоос?

-Бас нэг ажлын хэсэг гаргасан юм байна. Завсарлагын тухай хууль, УИХ-ын Дэгийн тухай хууль, УИХ-ын оорийнх нь хуультай холбогдсон хэд хэдэн хууль оргон баригдсан байгаа. Ардын намынхны оорийнх нь сонирхоод байгаа бүлэгтэй болох тухай хууль, Ардчилсан намынхны сонирхоод байгаа завсарлагыг хязгаартай болгох, ажлын таван одорт оруулах, зөвхөн тухайлсан асуудлаар завсарлага авдаг болох тухай гэх мэтчилэн асуудлуудаар С.Баярцогт гишүүнээр ахлуулаад МАН-аас хоёр Энхболд, УИХ-ын дэд дарга Л.Цог ороод ажлын хэсэг ажиллаж байгаа.

-Завсарлагааны тухай хууль чинь явах болов уу?

-УИХ дахь намууд хэр тохиролцохоос л болох болов уу. Ер нь бол намын бүлгүүд болон МАН-аас сонгогдсон гишүүдэд бололцоо олгож байгаа. Бүлэгтэй болох асуудал оороо том биш ээ. Том асуудлын ердөө жижиг хэсэг нь. Бусад улсын туршлага ч байна. Тухайлбал, Германы парламент шинээр бүрдэх болгондоо Дэгийн тухай хуулиа оорчлох үү гэдэг санал хураалт явуулаад олонхи нь “оорчилъе” гэвэл шинэ хууль гаргадаг. Тухайн дорвон жилд тохирсон хууль гэсэн үг. Гэтэл бид нэг хуулиар олонхитой парламент, олонхигүй парламентыг яг адилхан зохицуулах гэж оролдож байна. Яах вэ, хуулин дотор нь олонхитой бол тэгнэ, олонхигүй бол ингэнэ гэсэн гарц байгаа л даа. Германых шиг систем рүү орсон ч буруудах юм байхгүй, сонгогдсон парламент болгон оор оор онцлогтой байгаа. 2012 оны парламент гэхэд олонхигүй бөгөөд урьд омно парламентад байгаагүй нэг бүлэг шинээр гарч ирсэн байх жишээтэй. Түүнтэй холбогдуулаад зохих оорчлолтуудийг хийж байх нь зөв юмаа гэж харж байна.

Тэгэхээр Дэгийн тухай хууль бол зөвхөн нэг 24 цагийг оорчлох, эсвэл “ахмад гишүүн” гэдэг үгийг оорчлохоосоо гадна оорчлох гээд байгаа гол концепц нь байх ёстой. Парламент донгож байгуулагдаад “хуучин Дэгийн хуулиараа явах нь зөв” гэвэл тэр хуулиараа явж болдог. Болохгүй нь ээ, энэ удаагийн парламент ийм онцлогтой байна аа, энэ оорчлолтийг ингэж тусгая гэвэл хуулиа шинээр баталдаг, түүний дараа бусад томилгоонуудаа хийдэг байж болно. Хогжсон улсууд бодоод олчихсон байна л даа. Манай парламент хуучин дандаа олонхитой явж ирсэн учраас хэвчлэн анзаардаггүй байж. Олонхигүй болсон 2004 оны УИХ-д хоёр том нам нь хамтарч байсан учраас болж байсан байх. Олонхигүй болчихсон 2012 оны парламентад нэг том, нэг жижиг нам нь хамтарчихсан учраас хуулиар зохицуулагдаагүй зүйл үлдээд байна. Ийм зорилгоор хоёр дахь ажлын хэсгийг байгуулсан.

-Бүлэг байгуулах асуудлыг нь та яагаад ээлжит бус чуулганаар хэлэлцүүлээгүй юм, тэр хооронд парламент нэлээд олон томилгоонуудыг хийчихлээ шүү дээ?

-Угаасаа ээлжит бус чуулганы хэлэлцэх асуудалд ороогүй юм.

-Оорсдоо хуулийн тослоо хугацаанд нь оргон барьж хэлэлцэх асуудалд тусгуулаагвй учраас уу?

-Оргон барилаа ч гэсэн хэлэлцэх боломжгвй л байсан байхгвй юу. Хэлэлцэх асуудалд орно орохгвй гэдэг бол хэлбэрийн л асуудал шvv дээ. УИХ-ын гишvvдийн олонхи нь “наад асуудлыг чинь хэлэлцэхгвй ээ” гээд кноп дарчихвал энэ асуудал чинь хаагдчих гээд байгаа юм. Тэр зовшилцлоо хийгээгвй байсан учраас оруулаагвй. УИХ-д оргон баригдаад дорвон жил хэлэлцэгдэлгвй явж байгаа хуулийн тослvvд байна шvv дээ, найман жил болж байгаа нь ч бий. Нохцол нь бvрдэхгвй бол тэр хуулиуд угаасаа гарахгвй л дээ.

-Завсарлагааны тухай, бvлэг байгуулах тухай хуулиудын аль нь тvрvvлж батлагдах бол?

-Нэг хууль болгож, нэгтгэж хэлэлцэх учраас батлагдвал хоёулаа батлагдана. Батлагдахгвй бол хоёулаа одоо байгаа хэвээрээ л vлдэнэ. Гэхдээ тvрvvний миний хэлсэн хуулийн концепци нь оороо чухал байна шvv дээ. Парламент донгож байгуулагдаад хуучин хуулиараа явна гэвэл санал хурааж шийднэ, vгвй гэвэл шинэ хуулиа батлаад явна. Тэр нь тухайн дорвон зvйлийнхээ онцлогийг тусгасан байна. Мэдээж чуулган хуралдах, байнгын хороо хуралдах, хуулийн хэлэлцvлгийн дэс дараалал vндсэн заалтууд бол оорчлогдохгвй. Зохион байгуулалттай холбоотой, завсарлагаатай холбоотой, томилгоонуудтай холбоотой хэсэг нь бол оорчлогдож таарна.

-Онгорсон хугацаанд Засгийн газраас хийх ажлын тухай их ярилаа. Бvтцээ оорчилж, тосовтоо тодотгол хийлээ, морийн хотолбороо батлууллаа. Гэвч энэ дорвон жилд парламентын тvвшинд ямар оорчлолт шинэчлэлт хийгдэх бол оо? Омно яригдаж байсан болон одоо нийгэмд хvлээгдэж байгаа том том асуудлуудаас урагш алхах зvйл байна уу?

-Парламентын гаргаж байгаа хуулиуд нь оороо таны ярьж байгаа ажлуудыг хийх vндэс болдог. УИХ дахь олонхи нь Засгийн газраа байгуулдаг, олонхиор байгуулсан Засгийн газар нь толовлосон ажлаа л хийнэ. Парламент оороо Засгийн газар шиг “тэдэн сургууль цэцэрлэг барина” гээд яриад явахаасаа илvv тэрийг нь хийх нохцолыг бvрдvлж огдог. Хуулийг нь баталж, тосвийг нь бvрдvлж огдог, хяналтаа тавьдаг. Тvннээс биш бид реформ хийж байна гээд долоо хоногт нэг удаа болдог хуралдааныхаа одрийг оорчилдог шиг нэгдсэн чуулганаа долоо хоногт нэг болгодог зvйл хийгдэхгвй л дээ. Олон жил яваад туршигдчихсан, ажиллаж байгаа механизм байдгаараа л байна. Харин “парламент дээр энэ нь болохгвй байна, ажиллаж байгаа нохцолдоо тохируулаад оорчилье” гэвэл оорчилно л доо.

-Тухайлбал?

-Сая батлагдсан Засгийн газрын морийн хотолбор дотор хавсралт болгож нэг тогтоол баталсан. Засгийн газрын газрын морийн хотолбор дотор байх шаардлагагвй гэж vзсэн, гэхдээ зайлшгвй хийх шаардлагатай, эрх зvйн шинэчлэлтэй холбоотой тал хуудас зvйл бий. Эрх зvйн шинэчлэлийн эхний хэсгийг хийгээд дууссан, одоо хоёр дахийг нь заавал хийх ёстой. Эрvvгийн хууль, процессийн хуулиуд, Эрvvгийн байцаан шийтгэх хууль гэх мэт том том хуулиудын шинэчилсэн найруулгууд орж ирэх байх.

-Омно нь УИХ, Засгийн газар хоёр тус тусад нь байлгах, ядахдаа УИХ-ын гишүүн сайдын ажил хавсарч хийдгийг 1/3-ээр хязгаарлах, парламентын хяналтын үүргийг чангатгах гэх мэтчилэн олон зүйл энэ дорвон жилд дахиад хойш хаягдчихлаа. Бурууг нь мэдээж сонгуулийн үр дүнд огч байгаа, Ардчилсан нам олонхи болж чадаагүй учраас гэж. Ийм тохиолдолд УИХ Засгийн газраа хянаж байгаа гэдгийг оор ямар байдлаар итгэж үнэмшүүлэх юм бэ, онгорсон дорвон жил бүр байхгүй болсон зүйл шүү дээ?

-УИХ-ын Тамгын газар, түүний бүтцийн талаар эргэж харах зүйл байгаа. Байнгын хороодыг бэхжүүлэх замаар байнгын хороод болгон ооринхоо харгалзсан Засгийн газрын яам агентлагт илүү үр дүнтэй хяналт тавьж чаддаг болох ёстой. Одоо бол байнгын хороо хүнтэй ч юм шиг, хүнгүй ч юм шиг, ажиллаж байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг, хурал хийхээс хэтрэхгүй байна л даа. Ондор мэргэжлийн хүмүүсийг ажилд аваад тосвийнхоо хяналтаар дамжуулж Засгийн газрыг хянах үүрэг функция хэрэгжүүлэх хэрэгтэй. Хуульд бол тэр заалт байгаа. Тэрийгээ хэрэгжүүлэх хэмжээний хүн хүч, тосвоор байнгын хороод хангагдаж чадаагүй байгаа. Энэ алдааг залруулах хэрэгтэй. Хүчтэй байнгын хороодод тулгуурласан парламенттай болно. Би ийм зовлогоог урьд омно огч байсан, хэрэгжүүлээгүй.

-Хуулийн гол хэлэлцүүлгүүд явдаг байнгын хороод чинь аягүй чадавхигүй байна, дарга нар нь сул хүмүүс, гишүүд нь шинэ тутам байна гэж шүүмжлэгдээд байгаа. Үүнийг ажлын алба, аппаратын хүчээр дайна гэсэн үг үү?

-Байнгын хорооны дарга, гишүүд хэн байхаас үл хамаараад байнгын хороо нь оороо чадавхитай, солигддоггүй байх нь одоо ярьж байгаа шинэтгэлийн гол үндэс болно л доо. Ажлын алба, аппаратын ажилтнууд илүү чадавхитай байх ёстой.

-Ямар ч байсан хуучин шиг УИХ дээр гишүүд нэг зүйл яриад, Засгийн газар нь нэг зүйл яриад хоорондоо хэрэлдээд яваад байдаг нь болих нь ээ гэж ойлголоо. УИХ Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж, бас хянаж ажиллах нь ээ гэж ойлгох уу?

-Тийм. Ер нь бол УИХ-ын Тамгын газар, Байнгын хороодын аппарат илүү шуурхай, чанартай ажиллах ёстой. Тийм болж байж УИХ-ын ажлын үр дүн илүү харагдана. УИХ оороо улс төрийн шийдвэр гаргадаг. Тэр шийдвэр нь урт настай, богино настай байх бол харьцангуй юм. Улс орон оороо тогтвортой байхын тулд удаан хугацаанд амьдрах татвар, эрүүгийн хууль гэх мэтийг одор болгон шинэчлээд байж болдоггүй, тэр битгий хэл дорвон жилдээ шинэчилдэггүй. Одоо хуулийн байгууллагууд реформ хийх гэж байна. Бэлтгэл дорвон жил, эхний дорвон жил гээд арван хэдэн жилээр ажлаа товлородог, их инерцитэй салбарууд байгаа юм. Тэр зүйлүүд бол улс тороос хамааралгүйгээр хийгдээд явах ёстой. УИХ-ын Тамгын газар ч гэсэн байнгын хорооддоо тулгуурладаг, Тамгын газар нь тэдэндээ тусалдаг болчих юм бол үүнээс цааш оорчлох шаардлага байхгүй шүү дээ. Юм болгон харьцангуй. Аль нэг тал нь зов, ногоо нь буруу гэхээсээ илүү оноодрийн Монголын нохцолд юу нь ажиллаж, юу нь болохгүй байна гэдгээс л шалтгаалж ходолно л доо.

-Гэхдээ омнох УИХ-уудаас овлогдож ирсэн, олон жил яриад ажил болдоггүй асуудлууд байна шүү дээ. Үндсэн хуулийн оорчлолт, засаг захиргааны хуваарийн оорчлолт, улс

торийн намуудын хууль гэх мэтчилэн. Тэр асуудлууд чинь яг хэзээ УИХ дээр орж ирэх юм бэ? Аль алийг нь танай нам цоонх байхдаа ярьдаг л байсан сэдвүүд шүү дээ?

-Үндсэн хуулийн оорчлолт явахгүй байна гэдэг нь нохцол бүрдээгүй байна аа л гэсэн үг. Ярьдаг хүмүүс нь цоохон байна. Үндсэн хуулийн оорчлолт МАН-ынхны яриад байгаа тэр том зовшилцлийг үргэлж шаардаж байгаа. МАН-ын гишүүд УИХ-ын даргыг томилох асуудал дээр их том зовшилцол ярьсан шүү дээ, УИХ-д суудалтай бүх намтай зовшилцох үүрэгтэй энэ тэр гээд. Үндсэн хуулийн оорчлолт яг тийм зовшилцлийг шаардаж байгаа. Тийм зовшилцол байхгүй бол Үндсэн хуулийн ямар ч оорчлолт явахгүй.

-Онгорсон парламентын үед танай намаас санаачлаад энэ оорчлолтийн асуудлаар УИХ дахь бас нэг том нам болон МАН-тай зовшилцоод эхэлчихсэн байсан шүү дээ. Энэ зовшилцол яагаад зогсох ёстой гэж?

-Жишээ татъя л даа. Омох парламентын үед завсарлагын тухай хуулийг оргон барьсан гишүүд нь О.Энхтүвшин, Ч.Сайханбилэг гэх мэтийн гишүүд байгаа. Сонгуулийн омно хэн ялах нь тодорхойгүй байсан учраас “Энэ завсарлага торийн ажилд саад болж байна, хугацаагүй завсарлага авдгийг болиулья, хугацаатай болгоё” гээд хуулиа хэлэлцээд бараг дуусч байсан шүү дээ. Одоо завсарлагын асуудал ороод ирэхэд Байнгын хороо дүгнэлтээ уншаад “За хуулиа баталья” гээд алх тогшчиход л дуусч байгаа юм. Ямар ч санал хураалт байхгүйгээр. Гэтэл сонгуулийн дараа МАН-ын дарга О.Энхтүвшин “Бид их буруу бодож байсан байна, хугацаагүй завсарлага байх ёстой юм байна” гэж хэлсэн. Сонгуулийн үр дүнгээс хамаараад намуудын болон гишүүдийн байр суурь оорчлогдоод байгаа байхгүй юу. Тийм учраас тодорхой юм ярихад маш хэцүү. Зүгээр нэг завсарлагын хууль дээр тэгж байгаа улсууд Үндсэн хуулийн оорчлолтийг явуулах уу. Сая Орон нутгийн сонгуулийн хуулийн оорчлолттой холбоотойгоор сумын Засаг даргыг иргэд шууд сонгодог байхаар Үндсэн хуульд оорчлолт хийх гэж оролдлоо шүү дээ. Түүнээс болоод Орон нутгийн сонгуулийн хууль ч гэсэн харз насан байдалтайгаар хэд хоносон. Бас л болсонгүй. Бүгдээрээ л “Сумын Засаг ИХ-ын 21 гишүүнээс хараат байдаг, тэдэндээ үйлчлэлгүй болиулья, иргэд шууд сонгодог болъё” гэж ярьж байсан мортлоо “Тэгвэл Үндсэн хуулийнхаа оорчлолтоор үүнийг баталгаажуулчихъя” гэхээр “Аа больё, бодоодохъя” гээд хойш тавиад эхэлж байна. Яриа бол зондоо байгаа. Үндсэн хуулиа оорчилъё гэж байна, засаглалын хэлбэрээ ч оорчилъё гэсэн хүмүүс байгаа. Энэ бүхэн ажил болохгүй байна. Ажил болохын тулд нийт гишүүдийн ¾-ын санал авч байж энэ бүх оорчлолт явна. Хуралд оролцсон гишүүдийн биш шүү, УИХ-ын нийт гишүүдийн ¾-ын саналаар.

-Танай намынхан тэгвэл яагаад дуугарахгүй байна, дахиад дараагийн сонгууль дохвуулж байгаад дуугарах юм уу?

-Манай намынхан бол асуудлаа чирж явах ёстой олонхи шүү дээ. Олонхи энэ асуудал дээр цоонхийнхоо аяыг харахаас оор арга байхгүй. Гишүүн болгоны, нам болгоны зовшилцол хэрэгтэй. Хот тосгоны хуулиас авахуулаад үргүй зардал гарч байгаа олон асуудал бий шүү дээ. Хуучнаар Булган аймаг гэж байсныг дотор нь Орхон аймаг гээд байгуулчихсан. Сэлэнгэ аймаг гэж байсныг дотор нь Дархан-Уул аймаг гэж гуравхан сумтай аймаг үүсгээд Сэлэнгэ аймгийн Дарханыг тойрсон хүмүүс Дарханаас

вилчилгээгээ авдаг болгочихсон. Толовлот хийхэд маш хэцүү. Энэ мэтээр хотуудыг цоо шинээр эргэж харах ёстой юм. Хотын сонгууль гэдэг аймгийн сонгуулиас огт оор. Хот оорийн гэсэн дүрэмтэй, оорийн стандарттай юм байна гэдгийг одоо л анзаарч эхэлж байна.

Үндсэн хуульд 2000 онд ганц удаа оорчлолт оруулсан, дордуулсан долоон оорчлолт гэдэг нэртэй. Түүнээс хойш 12 жилийн турш Үндсэн хуулийн оорчлолтийг ярилаа, ажил болсон зүйл нэг ч байхгүй. Одоо бол Ардчилсан намын морийн хотолбор дотор аймгийн товчдийг хот болгоно гэсэн зүйл явж байгаа. Хот гэдэг аймаг биш, сум биш, дүүрэг ч биш. Оор хуультай, оор сонгуультай. Дэлхийн хотуудын жишиг байна л даа. Сүлжээ нь нэг байгаа газрыг л хот гээд байгаа юм. Цахилгаан, дулаан, тээвэр энэ бүх сүлжээ нь нэг бол нэг хот, энэ сүлжээ хоёр болчих юм бол хоёр дахь хот. Ийм нэг барих юмтай болохгүй бол нэг цахилгаан түгээх сүлжээнээс цахилгаанаа авдаг, нэг дулаан түгээх сүлжээнээс дулаанаа авдаг Улаанбаатар хотын дорвон уулын дундах нэг хэсгийг дорвон дүүрэг болгочихоод байгаа нь оороо бас л эргэж харах зүйл. Яг эндээ ингэж олон дүүрэг байх ямар хэрэг байгаа юм. Сүлжээгээ дагасан энэ хэсгээ нэг хот гэж нэрлээд хажуугийнхыг нь дагуул хот болгоё л доо. Налайх бол дүүрэг биш дагуул хот л байхгүй юу. Багануур ч бас дагуул хот. Оор оорийнхоо сонголтоор, тэнд амьдарч байгаа хүмүүсийнхээ олонхийн саналаар асуудлаа шийдэж байх ёстой. Ингэж асуудлыг харахгүй дүүрэг бол сум юм, аймгийн тов бол сум юмаа гэж яриад байдаг. Гэтэл 30.000 хүнтэй сум, 3000 хүнтэй сум хоёрын хооронд шал оор зарчмын ялгаа гарч байна шүү дээ.

-Орон нутгийн сонгуулийн хуульд үүнийг тооцсон уу?

-Орон нутгийн сонгуулийн хууль дээр энэ ялгаа маш тод харагдсан шүү дээ. Тэгээд Гончигдорж гишүүн аргаа ядахдаа хүн амын тоог харьцангуй ойр байлгахын тулд томьёо хүртэл бичлээ. 3000 хүнтэй сумын сонгууль, 30.000 хүнтэй аймгийн товийн сумын сонгууль хоёр шал оор юм байхгүй юу.

-Тооных нь харьцааг ойртуулж чадсан уу?

-Ер нь бол ойртуулсан. Хүн амын тоо болон засаг захиргааных нь нэгжийг аль алиныг нь тооцсон хоёр хувьсах үзүүлэлтийг тооцож гаргасан ИХ-ын гишүүдийн тоо байгаа. Сонгууль оороо хялбархан байх ёстой л доо. Манай сум болгоноос нэг хүн аймгийн ИХ-д суух юм байна гээд нэг мандаттай мажоритари сонгууль явуулах юм бол хүн болгон ойлгоно. Гэх мэтээр засаг захиргааны хуваарийн оорчлолт бас л цаг нь тулчихаад шийдлээ хүлээж байгаа асуудал. Одоо бол орон нутгийн сонгуулийг аргалаад л явуулаад байгаа. Энэ бүх зүйл улс тороосоо хамаараад хэзээ нэгэн цагт шийдэгдэх ёстой. Тэр цаг нь хичнээн түргэн байна, тодий чинээ л сайн байх.

-Гэхдээ омо нь Ардчилсан нам цоонх байхдаа энэ асуудлыг гаргаж тавьж л байсан, ногоо намаа ч шахаж шаарддаг байсан. Одоо харин эрх баригч хүчин нэр зүвсэн хойноо бэрхшээл тоочоод суух нь жаахан тааруухан л харагдаж байна?

-Бид УИХ дээр хэнтэй ч ярилгвйгээр асуудлаа авч явах хэмжээний суудал авч чадсангвй л дээ. Тэр нь 39 суудал, ирцээ бүрдүүлээд л асуудлаа шийдээд явдаг. Үндсэн хуулийн

оорчлолт бол бvх хvнтэй ярьдаг оор тvвшингийн асуудал. Тиймээс зайлшгvй зовшилцох vврэгтэй, ялангуяа Үндсэн хуулийн оорчлолт дээр. Аймгийн товvвдийг хот болгох ёстой. Хотын сонгууль, дvвргийн сонгууль, сумын сонгууль гэдэг оор байна. Толооллийн ардчилал учраас толооллоо яаж бvрдvвлэх вэ гэдгээс л бvх юм эхэлнэ шvв дээ. 200.000 хvнтэй нэг дvвргийг 40-50 мянган хvнтэй жижиг аймагтай адилтгаж вэж сонгуулийг нь явуулж болохгvй л байхгvй юу. Нэгэнт тэр дvвргийн, тэр аймгийн бvрэн толоолол болж чадахгvй ИТХ-тай болчихсон бол тэр хурал нь дахиад дорвон жилийн хугацаанд оорчлолт авчирахгvй л гэсэн vг. Ийм гинжин урвал эхэлчихсэн учраас зогсоож чадахгvй байна. Зогсоох арга нь бvх юмаа тохироод Үндсэн хуулиндаа оорчлолт хийгээд дараагийн 10-20 жил Үндсэн хуулиндаа гар хvрэхгvйгээр тохиролцсон схемээрээ сонгууль гэх мэт бvх ажлаа явуулна гэсэн vг.

-Уг нь та УИХ-ын сул гишvвн, Байнгын хорооны дарга байхдаа их олон асуудлыг гишvвдийнхээ омно нь гараад чирч явдаг цоон гишvвний нэг байсан. Одоо бол зvгээр л олон намын эрх ашгийн уулзвар дээр сууж байдаг хvн болсон юм байна, тийм vв?

-Тэр нь миний vврэг болсон. УИХ-аар асуудал гаргах vврэг л надад байгаа.

-Танай намын бодлого, морийн хотолбор энд хамаагvй гэсэн vг vв?

-Морийн хотолбор, олонхийг дэмжиж ажиллах vврэгтэй. Асуудлын дарааллууд бас байна л даа. Ердийн олонхиор шийддэг асуудал ихэнх нь байгаа, 100-ны 90 хувь. Гишvвдийн 2/3-оор шийддэг асуудал байна, жишээ нь Хvний хогжил сангийн хуулийн оорчлолт. Нийт гишvвдийн 3/4-аар шийдэх ёстой асуудал гэх мэтчилэн асуудал болгоныг шийддэг тvвшин нь оор. Энэ тvвшинд нь тохирсон зовшилцлvвдийг хийж байж асуудал шийдэгдэнэ.

-Гэхдээ онгорсон хугацаанд УИХ-ын даргын томилгоо, ээлжит бус чуулганаар хэлэлцсэн асуудлууд, Монголбанкны еронхийлогчийн томилгоо, МАН-ын бvлэг байгуулах тухай хуулийг тослийг хэлэлцvвлээгvй явдал энэ тэр дээр бол цэвэр таны оорийн байр суурь, эсвэл намын эрх ашиг явсан л гэж би хувьдаа харж байгаа. Оор олон асуудлыг ингэж шийдэж болдоггvй юм уу?

-Би МАН-ын гишvвдийг дэмжээд ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудалд оруулчихья гэж бодъё л доо. Хэлэлцэх эсэхийг нь гишvвд бvгдээрээ байнгын хороо, нэгдсэн чуулган дээр кнопдоно шvв дээ. Ардчилсан намын бvлэг, “Шударга ёс” эвсэл хоёр нийлээд эсрэг санал огчих юм бол МАН-ын бvлэг байгуулах асуудал нэг мосон хаагдана. Дахиж УИХ дээр орж ирэхгvй. УИХ оорийгоо илэрхийлчихэж байна шvв дээ, “МАН-ыг бvлэгтэй болгох асуудал энэ дорвон жилд яригдахгvй ээ, яагаад гэвэл эд хуулиа зорчсон” гээд. Асуудлыг тэгээд мухарлачихаар МАН-д оорт нь хайран байхгvй юу. Тиймээс би МАН-ынханд “Асуудал нь 3.Энхболдод байхгvй ээ. Хэлэлцэх эсэх дээр та нарыг дэмжиж кноп дардаг тэр улсуудтайгаа л ярь” гэдэг зовлогоо огсон. Ардчилсан нам, “Шударга ёс” эвслийн 44 хvнтэй бvгдээрэнтэй нь ярь гэсэн vг биш шvв дээ. УИХ хоёр бvлэгт хуваагдчихсан байна, цаана нь нэг нам, хоёр бие даагч байна. Энэ улсуудтайгаа л ярьж юмаа дэмжvвл. Миний вэжээс хамаарахгvй байхгvй юу. Хорь хоногийн дараа “Бvлэг байгуулья” гээд ороод ирэхэд хуулинд “Бvлгийг 24 цагийн дотор байгуулна” гээд

биччихсэн байгаа учраас л болохгүй байгаа юм. Түүнээс биш З.Энхболд Ардын намд дургвйдээ бвлэггвй байлгаад байгаа асуудал ероосоо биш. Хуулинд тэгээд биччихсэн, би хуулийг дагаж мордоно гээд тангараг оргочихсон учраас "Ардын нам бвлэггвй арай хэцвв, оровдмоор байна аа. Бвлэг байгуулаад огчихье" гэдэг дур зоргын, вээмжийн асуудал байхгвй.

-Омно нь УИХ зондоо л олон удаа хуулиа зорчиж байсан швв дээ?

-Тэр бол тэр УИХ-ын асуудал. Миний вед хууль зорчихгвй. Ялгаа нь ердоо л энэ. УИХ бусад торийн байгууллагууд, иргэдэд влгэр вэввлж байгаа юм. Бвгдээрээ хуулиа мордож ажиллая. Урьд нь хууль хэрэгждэггвй байсан, тэрийгээ цэгцэлье гэж. Оноодор нэг дэх одор. Нэг, зургаагаар тогссон дугаарлалттай машин явахгвй. Үвнээс болоод Улаанбаатарын замын ачаалал 20 хувиар буурч байна швв дээ. Хагас бвтэн сайн болохоор бвх машин гардаг учраас "замын твгжрэл их байна" гэдэг стресс нь эхэлдэг. Машины дугаарын тархалт жигд байна гэж вээх юм бол хорин хувийнхаа ачааллыг Улаанбаатар хот оороо ухамсартайгаар зохицуулаад эхэлчихлээ. Нэмэгдэл зардал гарч байгаа, тэр цэнхэр хувцастай хвмввсийн цалин гэх мэтэд. Тэрнээсээ хамаагвй илвв ашгийг Улаанбаатар хот олж байгаа. Хвмввсийн цаг, нервийн хэмнэлт, стресс буурах хэмжээгээр эрввл мэндэд ашигтай гэх мэтчилэн. Хууль дврмээ сахиж биелввлэх нь том хотын хувьд зайлшгвй болж байна.

-Хотын асуудлын хувьд тийм ээ. Харин УИХ дээр яг ввн шиг оорчлолт зэрэгцээд явж болдоггвй юм уу? Шинэ агаар салхи орж ирэхгвй, хуучнаараа л ажиллаж байгаа харагдаад байх юм, хвмввс яараад байдаг?

-/Инээгээд/ Анхдугаар чуулган дуусаад ээлжит бус чуулганаар юу юу шийдсэнийг чи оороо эргээд хар л даа. Хвмввс аягвй мартамхай байгаа байхгвй юу. Олон жил яригдсан Орон нутгийн сонгуулийн хууль батлагдсан, МАН-ын оролцоотойгоор. 2012 онд УИХ, орон нутгийнхаа сонгуулийг нэг системээр явуулья гээд бид яриад МАН-ын саналыг хвлээж авсан. Омно нь улс торийн намуудын толоололоор тойрог, хэсгийн хороодыг бврдовлдэг байсныг зовхон торийн албан хаагчдаар бврдовлдэг болсон. Энэ мэтээр зовшилцол явж байгаа. Сонгуулийн хууль бол зайлшгвй сонгуульд оролцох гэж байгаа нам, эвсэл, бие даагчдын саналыг авч байж гарах ёстой хууль. Энэ бол том дэвшил. Тосвийн орлого алга болсон, хямрал айсуй. Үвнд тааруулсан тодотголоо бас нэг их удаалгвй баталсан. Хввхдийн монгоний хвлээлт байсан, ввнийг бас баталсан. Бвх хвнд хавтгайруулсан халамж огдгийг болиулсан, зорилтот хэсэгтээ толовлосон. Тэр нь хввхэд.

-МАН-ын 21 мянга батлагдаагвй юу?

-Тэр монгоний эх ввсвэр байхгвй. Хввхдийн монго бол ердоо 58 тэрбум байгаа швв дээ, ногоох нь хввхдэд огдогоос гурав дахин их монго гээд бодохгвй юу. 900 мянган хввхдэд огох, 2,7 сая хвнд 21 мянгыг огох хоёр чинь оор. Хввхдийн монгийг бол тосвийнхоо хэмнэлтээс гаргаж болж байгаа юм. Олон жилийн оноос яригдсан "ажилласан жил"-ийн асуудал байна. Оороос нь вл шалтгаалах шалтгаанаар ажилласан жил нь тасалдсан хвмввс нийгмийн даатгалын шимтгэлээ нохож толох юм бол бвтэн тэтгэвэртэй болж



байгаа. Ийм асуудлуудыг шийдээд явж байгаа. Үүнийг хэвээр реформ гэж харахгүй, УИХ хийх ёстой юмаа л хийж байна гэж хардаг. Уг нь бол үнэхээр тулгамдсан асуудлыг хэсэг бүлэг хэвээр хурал хаяуулчихалгүй шийдээд л яваад байгаа юм. Манай УИХ-ын сурталчилгаа муу байж магадгүй, хийсэн ажлаа тайлагнах тал дээр.

-Шинэ дэвшилттэй зүйл гаргаж ярих нь бага хэрнээ хуучнаа ухарч ярьдаг байдал л үргэлжлээд байгаа юм биш үү? Тавантолгойн асуудал огт яваагүй байхад л дахиад ногоо “эх орончид” нь гарч ирээд, “Оюутолгойн гэрээг оорчилно” гэж яриад, хоронго оруулагчид, гадаад орчинд хоорол үүсгээд л...

-Зовхон Оюутолгойн гэрээ биш, нийтдээ 16 гэрээ байна. 1990 онд байгуулсан бүтээгдэхүүн хуваах хэлэлцээрээс авахуулаад, түүний дараа “Бороо Гоулд”-тай байгуулсан тогтвортой байдлын гэрээг оруулаад. Тэр үед уул уурхайн хоронго оруулалтын асуудал дээр олон нийтийн оролцоо, хяналт тийм сайн байсангүй. Энэ 16 гэрээг бүгдийг нь авч үзье, зовхон Оюутолгойг салгаж үзэх нь буруу байна аа гэдэг шийдвэр гарсан. Түүнээс биш Оюутолгойн гэрээнд оорчлолт оруулахгүй гэж хэн ч яриагүй. Ийм санал хураалт явсан, тэр талаар буруу зорьж ойлголтыг хэвлэлээр зориудаар тарааж байгаа зүйл байна лээ. Анхны Засгийн газрын оргон мэдүүлсэн санал яаж оорчлогдсон, тэр хоёрын аль нь илүү улсын ажилд хэрэгтэй байна. Тэр талаас нь хараад анализ хийгээд үзвэл дараагийнх нь хамаагүй илүү, бүх талыг хамарсан байгаа. Энэ дорвон жилийн хугацаанд бид энэ 16 гэрээн дээрээ анализ хийгээд, үнэлгээ дүгнэлт огоод ирээдүйд байгуулах гэрээн дээрээ сургамж авах ёстой. Оюутолгойн асуудал бол тодорхой шүү дээ. УИХ-ын 57 дугаар тогтоол байгаа, тэр бодлого оорчлогдохгүй.

-Гэхдээ тогтоолын хэрэгжилтийг хангах хугацаа болоогүй, шаардлагуудыг хангах ажлууд нь хийгдээгүй байгаа шүү дээ?

-Тийм ээ, болоогүй, хугацаа байгаа. Тэгэхээр бид урьд олно алдаа хийсэн байж магадгүй, гэрээ болгон дээр нээлттэй хэлэлцүүлэг хийе гэдэг саналаа би УИХ дээр хэлсэн. Урьд нь байгуулсан бүх гэрээгээ оноодрийн тэнгэрт хадсан зэсийн үнэ, алтны үнэ дээр ярихад оор л зүйл харагдана. Гэрээ болгон оорийн байгуулагдах үеийн ноцоллолттой. Тэр ноцоллолттойгээ таарч хийгдсэн үү, үгүй юу гэдэг л асуудал байгаа. Мэдээж бүгдийг нь нэг шалгуураар шалгана гэвэл бүх орд улсынх байна, хэний ч оролцоогүйгээр оороо авч явна гэдэг нэг талын туйлшрал байна. Ямар ч хувь хэлцэлгүйгээр 100 хувь хувьд нь огоод улс зовхон татвараа аваад явна гэдэг бас нэг хувилбар байна. УИХ энэ хоёрын дундуур л яваад байгаа шүү дээ. Тэгэхээр аль нь зов, аль нь буруу байсан бэ гэдэг дээр гишүүддээ мэдээлэл огох хэрэгтэй, олон тэмэн ч гэсэн мэдээлэл олж авах эрхтэй.

-Тэр хугацаанд одоо хүлээгдэж байгаа ордууд чинь ашиглагдах уу, үгүй юу? Жишээ нь, Тавантолгой яаж явах гээд байгаа юм?

-Одоо бол нэг их гэрээ хийгдэх гээд хүлээгдээд байгаа ордууд байхгүй. Тавантолгойн орд 100 хувь улсын омч учраас тэнд хоронго оруулалтын юм уу тогтвортой байдлын гэрээ хийгдэхгүй. Лицензээ огч явуулахгүй, улс оороо цаашаагаа гэрээлэх учраас тэнд хохирол бага гарч байгаа. Тавантолгой компанийн нүүрсээ ухуулах гэрээ, тээвэрлэх, цаашаагаа

борлуулах гэрээнүүд л сайн байвал болж байгаа юм. 30-40 жилээр хаагаад хаячих зүйл байхгүй, түрүүн хэлсэн гурван торлийн гэрээн дээр буруудлаа гэхэд тэр дор нь цуцлаад, дараагийнхыг шалгаруулаад явдаг уян хатан зохицуулалттай байх юм. Оюутолгой бол тэр газар дор хэдэн тонн зэс, алт байгааг мэдэлгүйгээр хийсэн гэрээ. Тавантолгойн хувьд хэдэн метрийн гүнд хэдэн метрийн зузаантай, ямар чанартай нүүрс байгааг бид мэдэж байгаа учраас энэ ордыг ажиллуулахад илүү хялбар байгаа юм.

-Сая Засгийн газар байгуулагдсаны дараа нүүрсний үнэ унасан, худалдан авалт багассан гээд боон дуулиан болсон шүү дээ?

-Нүүрсний үнэ хэцүү байгаа, гэхдээ түвхийгээр нь зарах тухайд. Тэгэхээр боловсруулалтын түвшингээ л дээшлүүл гэсэн үг. Дэлхийн ган хайлуулалт буурч байгаа. Гэхдээ буурч байгаа ч гэсэн огт ган хайлуулахаа болихгүй шүү дээ. Тэгэхээр хэрэгцээ бол үргэлж л байна гэсэн үг.

-Дээр нь Монголын тороос уул уурхай дээр барих бодлого, хоронго оруулагчид хандах хандлага оорчлогдсон үү гэдэг асуултыг маш олон гадаадын хэвлэл тавьж байсан. Энэ асуултын хариу тодорхойгүй хэвээр байгаа?

-Уул уурхайн бодлого ямар болсныг оны эцсээр батлагдах Ашигт малтмалын тухай хуулийн хэлэлцүүлгээс харж болно. Тэр хууль яаж гарахаас харна гэсэн үг. УИХ-ын гаргаж байгаа хууль оороо бодлого. Ардчилсан намын морийн хотолборт орсон “А лицензийг Засгийн газар огно” гэдэг заалт УИХ-ын хуулинд суугаад гарчихна. Илүү хүнд сурталтай болгож байгаа. А лиценз хэдэн мянгаараа байж, газар сайгүй ухаад байж болохгүй гэсэн үг. Хязгаартай, хэдэн том тослоор цаашид амьдарна. Хайгуулын лицензийг арилжааны хэрэгсэл болгож байгаа улсуудад биш, үнэхээр хайгуул хийгээд юм барих гэж байгаад нь огдог механизм бий болгоно. “Цаас авсан л бол та тодорхой үүрэг хүлээнэ ээ. Чамд омч хоронго биш, эрхийн бичиг л огч байгаа юм. Эрхийн бичгээ ашиглаад жилдээ ийм ийм ажил хийгээгүй бол эрхийн бичиг чинь хүчингүй шүү” гэдэг болно. Эцсийн зорилго хайгуул биш шүү дээ. Эцсийн зорилго бол бүтээгдэхүүн.

-Гадаад талд, хоронго оруулагчдад бий болсон тэр савлагаа одоо намжсан уу, эсвэл хүлээлтийн байдалтай л байна уу?

-Ер нь бол хэтэрхий либераль байсан ашигт малтмалын салбар илүү мэргэжлийн болох ёстой. 2006 оноос омно бүр задгай байсан, 2006 онд нэг удаа хумьсан, одоо дахиад хумигдана л гэсэн үг. Үнэхээр л юм хийж байгаа компаниуд нь зах зээл дээрээ үлдэж, жижиг гарын ченжүүд нь алга болох ёстой. Үр ашиггүй, байгальд хоноолтэй үйл ажиллагаа явуулдаг жижиг уурхайнууд хаагдана. Хятадад сая 2900 жижиг уурхайг хаалаа гэж байна. Том улс болохоор тоо нь олон байна л даа. Байгаль орчин бохирдуулж байна, ходолморийн аюулгүй байдал хангахгүй байна.

-Манайд яг ийм шалтгаанаар хаагдсан уурхай одоохондоо байхгүй шүү дээ?

-Манайх ажиллаж байгаа уурхайнууд нь цоохон байна л даа. Урт нэртэй хууль гарсны дараа маш олон алтны жижиг уурхай хаагдсан шүү дээ. Нүүрсний ажиллаж байгаа

уурхай нь цоохон юм даа.

Ардын эрх сонин